



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙД Ж.ГАНБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2023.12.08 № 34

Дизель түлш болон АИ92 шатахууны
хүрэлцээ муу байгаа талаар

Монгол Улсын Их Хурлын гишүүн миний сонгогдсон тойрог болох Нийслэлийн Баянгол дүүргийн иргэдээс дизель түлш болон АИ92 шатахууны олдоц муу, хүртээмж хангалтгүй, нийлүүлэлт багасаж байна гэх гомдол, санал ихээр ирж байна.

Энэ нь иргэдийн өдөр тутмын хэрэгцээнээс гадна Уул уурхайн болон хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдэд хүндрэл учруулаад зогсохгүй хөдөө орон нутаг руу бараа бүтээгдэхүүн тээвэрлэхэд ч хүндрэл үүсгэж эхэлсэн гэх асуудлууд яригдаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Дизель түлш болон АИ92 шатахууны өнөөгийн нөөц, тасалдал үүссэн гол шалтгаан нөхцөлийн талаар;
2. Нийлүүлэлтийн төлөв байдал, хүлээгдэх хоног хугацаа авах арга хэмжээний талаар;
3. Дизель түлшний тасалдал үүссэнээр экспорт, импортод нөлөөлөх нөлөөлөл, улсын эдийн засагт үүсч болзошгүй эрсдэлт нөхцөл байдлын талаар;
4. Улсын хэмжээнд өдөрт хэдэн тонн түлш зарцуулагдаж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
5. Өдөрт зарцуулагдах хэрэгцээг хэр хэмжээнд хангаж чадаж байгаа талаар;
6. Дизель түлшний хомсдолоос ангижрах ямар гарц гаргалгаа, ойрын болон хэтийн төлөв байдал, авах арга хэмжээний талаар;

2023000126

7. Түлш шатахууны тасалдалаас үүдэлтэй өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөллийг судалсан эсэх, судалгааны талаар.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дотор ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ



2023000126